

## Экспорт, импортын боломжууд

Татварын  
буцаан олголт

Чөлөөт бүсэд барааг хилийн чанадаас оруулахад импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй; Монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулахад экспортын гаалийн албан татвартай бол түүнийг ногдуулж, нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгоно.

Гаалийн болон  
НӨАТ –ийн  
татвар байхгүй

Чөлөөт бүсээс барааг хилийн чанадад гаргахад экспортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй.

ЕХУлсууд руу  
татваргүй

Монгол улс 1997 онд дэлхийн худалдааны байгууллагын гишүүнд элссэнээр Европын Холбооны Улс руу 7200 нэр төрлийн барааг ямар нэгэн тарифын хязгаарлалтгүй, хөнгөлөлттэй нөхцлөөр оруулах боломж бүрдсэн.

39 улстай  
давхар  
татвараас  
чөлөөлөгдсөн

Монгол улсын Засгийн газар "давхар татвараас чөлөөлөх хэлэлцээрийг 33 улстай, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах 2 талт хэлэлцээрийг 39 улстай байгуулсан.

## ТААТАЙ ОРЧИН НӨХЦӨЛ

**Байршлын  
хувьд:**



-“Замын-Үүд” чөлөөт бүс нь Евро-Азийг холбосон худалдааны гол газарзүйн байрлал дээр оршдог.

-“Замын-Үүд” чөлөөт бүс нь газарзүйн байршлын хувьд давуу талтай ба бүсийн талбайг өргөжүүлэх хангалттай боломж байгаа учир газар ашиглахтай холбоотой бэрхшээл гарахгүй.

**Зах  
зээлийн  
хувьд:**



Монгол Улс гадаад худалдааныхаа 63,4 хувийг БНХАУ-тай хийдэг бөгөөд тус улстай хийж буй бараа эргэлтийн импортын 90%, экспортын 80 орчим хувь нь Замын-Үүд боомтоор дамжин өнгөрдөг.

**Цаг  
хугацааны  
хувьд:**



Евро-Азийг холбосон Монгол Улсыг дайрсан хуурай зам нь усан замаас 350 гаруй цагаар, Монгол Улсаар дайрсан Москва Бээжинг холбосон төмөр зам Манжуураас 1140 км-ээр дөт, цаг хугацааны хувьд хэмнэлттэй байдаг.